



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Иргэний нисэхийн үндэсний төв Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2023/1/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Баянхонгор 2023 оны 3 дугаар сарын 06</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат</p> <p>Утас: 99007576      Цахим хаяг: munkhatb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: А.Цээням</p> <p>Утас: 99442140      Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: М.Алтантуяа</p> <p>Утас: 99061861      Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	/төгрөгөөр/.....4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	/төгрөгөөр/.....4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	/төгрөгөөр/.....5
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	7
3.1 Байгууллагын үйл ажиллагаа .....	7
3.2 Компанийн гадаад дотоод орчин.....	7
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт .....	8
4. Аудитын тайлан .....	10
4.1 Ерөнхий зүйл .....	10
4.2 Материаллаг байдал.....	11
4.4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
4.4.1 Шилэн дансны мэдээлэл.....	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
4.5.1 Завсрын аудитын талаар .....	12
4.5.2. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
5. Аудитын илрүүлэлт.....	12
5.1 Зөвлөмж.....	13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	14

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИНҮТ	Иргэний нисэхийн үндэсний төв
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584  
Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2021.03.05 № 2/111  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Иргэний нисэхийн үндэсний төв Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Иргэний нисэхийн үндэсний төв Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд өөрийн орлогоор 5,500.0 мянга, Иргэний нисэхийн ерөнхий газраас 1,021,199.8 мянга, нийт зардлыг 1,026,699.8 мянган төгрөг байхаар баталсан ба гүйцэтгэлээр 985,322.5 мянган төгрөг орлого орж, 1,044,651.1 мянган төгрөг зарцуулж 58,874.0 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

• 005020438

## **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 39 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Баянхонгор Нисэх буудалд 2022 онд онцгой үүргийн 6, тусгай үүргийн 9, түргэний 35 нислэг тус тус үйлдсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Б.МӨНХБАТ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	43,210,333.50	25,206,142.95
1.1.2	Дансны авлага	4,218,893.80	0
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	17,431.53	1,143,450.04
1.1.4	Бусад авлага	2,958,631.03	5,821,924.79
1.1.6	Бараа материал	32,692,013.93	42,955,991.45
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	0	516,042.00
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>83,097,303.79</b>	<b>75,643,551.23</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,008,245,079.17	1,288,771,076.07
1.2.2	Биет бус хөрөнгө	1,034,117,601.49	1,068,485,543.14
1.2.7	Хойшлогдсон татварын хөрөнгө	10,426,866.69	10,668,596.73
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>2,052,789,547.36</b>	<b>2,367,925,215.94</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,135,886,851.15</b>	<b>2,443,568,767.17</b>
2.1.1.4	НДШ - ийн өглөг	120,500.00	0
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	49,431.53	0
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>169,931.53</b>	<b>0</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>169,931.53</b>	<b>0</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>	<b>1,519,736,486.75</b>	<b>1,886,462,330.77</b>
2.3.1	Өмч: - төрийн	1,030,960,000.00	1,030,960,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	488,776,486.75	855,502,330.77
2.3.9	Хуримтлагдсан ашиг	615,980,432.87	557,106,436.40
	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>2,135,716,919.62</b>	<b>2,443,568,767.17</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,135,886,851.15</b>	<b>2,443,568,767.17</b>

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөр	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Борлуулалтын орлого (Цэвэр)	4,695,254.80	7,653,274.55
2	Борлуулалтын өртөг	928,893,768.24	958,167,652.80
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>-924,198,513.44</b>	<b>-950,514,378.25</b>
4	Түрээсийн орлого	0	454,545.45
8	Бусад орлого	1,005,959,316.59	977,669,262.17
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,500,000.00	1,500,000.00
12	Бусад зардал	73,186,123.55	84,983,425.84
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>7,074,679.60</b>	<b>-58,873,996.47</b>
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг ( алдагдал)</b>	<b>7,074,679.60</b>	<b>-58,873,996.47</b>
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>7,074,679.60</b>	<b>-58,873,996.47</b>
<b>28</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>	<b>7,074,679.60</b>	<b>-58,873,996.47</b>

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,030,960,000.00	488,776,486.75	608,905,753.27	2,128,642,240.02
3	Залруулсан үлдэгдэл	1,030,960,000.00	488,776,486.75	608,905,753.27	2,128,642,240.02
4	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	0	0	7,074,679.60	7,074,679.60
9	2021 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	1,030,960,000.00	488,776,486.75	615,980,432.87	2,135,716,919.62
11	Залруулсан үлдэгдэл	1,030,960,000.00	488,776,486.75	615,980,432.87	2,135,716,919.62
12	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	0	0	-58,873,996.47	-58,873,996.47
14	Өмчид гаргасан өөрчлөлт	0	366,725,844.02	0	366,725,844.02
17	2022 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	1,030,960,000.00	855,502,330.77	557,106,436.40	2,443,568,767.17

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0	0
1.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>808,706,529.00</b>	<b>835,040,576.10</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	627,616.00	5,132,377.80
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	807,465,000.00	821,804,600.00
1.1.6	ҮҮА-ны бусад мөнгөн орлого	613,913.00	8,103,598.30
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>804,189,222.29</b>	<b>853,044,766.65</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	402,740,960.00	408,892,778.03
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	122,712,115.46	107,100,306.49
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	124,635,060.00	142,852,955.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	31,568,997.40	34,730,198.82
1.2.6	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	57,887,000.00	70,944,500.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	47,556,589.43	47,505,429.43
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	4,843,000.00	16,106,615.88
1.2.9	ҮҮА-ны бусад мөнгөн зарлага	12,245,500.00	24,911,983.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,517,306.71	-18,004,190.55
4	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>4,517,306.71</b>	<b>-18,004,190.55</b>
4	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	4,517,306.71	-18,004,190.55
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>38,693,026.79</b>	<b>43,210,333.50</b>
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>43,210,333.50</b>	<b>25,206,142.95</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны гүйцэтгэл	2022 оны Тодотгол		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
НИЙТ ЗАРЛАГА	803,489,221.4	1,026,699,800.0	849,142,483.7	177,557,316.3	82.7
НИЙТ УРСГАЛ ЗАРДАЛ	803,489,221.4	1,026,699,800.0	849,142,483.7	177,557,316.3	82.7
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	802,339,221.4	1,020,699,800.0	845,830,483.7	174,869,316.3	82.9
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	483,306,347.0	601,220,800.0	486,339,476.2	114,881,323.8	80.9
1 Үндсэн ба нэмэгдэл цалин	414,036,347.0	523,992,500.0	412,374,476.2	111,618,023.8	78.7
2 Унаа хоолны хөнгөлөлт	69,270,000.0	77,228,300.0	73,965,000.0	3,263,300.0	95.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,635,057.0	75,152,600.0	57,501,305.7	17,651,294.3	76.5
1 Тэтгэврийн даатгал	43,870,757.0	51,103,800.0	40,804,011.7	10,299,788.3	79.8
2 Тэтгэмжийн даатгал	4,897,000.0	6,012,200.0	4,804,894.4	1,207,305.6	79.9
3 ҮОМШ-ийн даатгал	8,813,700.0	4,809,800.0	2,743,867.9	2,065,932.1	57.0
4 Ажилгүйдлийн даатгал	823,000.0	1,202,400.0	831,684.7	370,715.3	69.2
5 Эрүүл мэндийн даатгал	8,230,600.0	12,024,400.0	8,316,847.0	3,707,553.0	69.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,468,650.0	59,552,800.0	57,741,282.9	1,811,517.1	97.0
1 Гэрэл, цахилгаан	24,632,450.0	28,527,800.0	27,131,232.9	1,396,567.1	95.1
2 Түлш, халаалт	27,792,200.0	30,625,000.0	30,610,050.0	14,950.0	100.0
3 Цэвэр, бохир ус	44,000.0	400,000.0	0.0	400,000.0	0.0
Хангамж, бараа материалын зардал	70,666,407.4	80,372,100.0	77,209,055.9	3,163,044.1	96.1
1 Бичиг хэрэг	4,398,800.0	1,393,000.0	1,385,000.0	8,000.0	99.4
2 Тээвэр, шатахуун	53,137,600.0	62,437,800.0	62,434,000.0	3,800.0	100.0
3 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,971,057.4	9,430,000.0	7,148,965.9	2,281,034.1	75.8
4 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,301,100.0	4,799,300.0	3,944,000.0	855,300.0	82.2
5 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,857,850.0	2,312,000.0	2,297,090.0	14,910.0	99.4
Нормативт зардал	2,250,000.0	17,285,000.0	17,285,000.0	0.0	100.0
1 Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,250,000.0	17,285,000.0	17,285,000.0	0.0	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	93,029,510.0	113,591,300.0	106,158,963.0	7,432,337.0	93.5
1 Багаж, техник, хэрэгсэл	37,739,080.0	71,412,100.0	68,880,333.0	2,531,767.0	96.5
1 Тоног төхөөрөмж	15,273,980.0	37,000,000.0	38,650,033.0	-1,650,033.0	104.5
2 Автомашин	7,840,000.0	11,144,100.0	6,402,000.0	4,742,100.0	57.4
3 Аэродром	10,221,100.0	22,030,000.0	21,929,300.0	100,700.0	99.5
4 Гал унтраах зардал	4,404,000.0	1,238,000.0	1,899,000.0	-661,000.0	153.4
5 Хөдөлмөр хамгааллын зардал	9,731,860.0	11,615,200.0	6,715,500.0	4,899,700.0	57.8
6 Урсгал засвар	45,558,570.0	30,564,000.0	30,563,130.0	870.0	100.0
Томилолт, зочны зардал	14,108,200.0	18,000,000.0	20,300,400.0	-2,300,400.0	112.8
1 Дотоод албан томилолт	14,108,200.0	18,000,000.0	20,300,400.0	-2,300,400.0	112.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,875,050.0	47,625,200.0	19,157,148.0	28,468,052.0	40.2

1	Харуул, хамгаалалтын зардал	400,000.0	1,543,500.0	1,513,100.0	30,400.0	98.0
2	Үл хөдлөх хөрөнгийн татвар	7,946,804.0	8,370,100.0	8,185,052.0	185,048.0	97.8
3	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,386,610.0	3,350,000.0	1,833,600.0	1,516,400.0	54.7
4	Даатгалын үйлчилгээ	4,843,000.0	6,192,500.0	6,192,500.0	0.0	100.0
5	Тээврийн хэрэгслийн татвар	588,064.0	630,000.0	606,204.0	23,796.0	96.2
6	Газрын төлбөр	546,192.0	27,359,100.0	715,392.0	26,643,708.0	2.6
7	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	164,380.0	180,000.0	111,300.0	68,700.0	61.8
Бараа үйлчилгээний бусад зардал		2,000,000.0	7,900,000.0	4,137,852.0	3,762,148.0	52.4
1	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.0	5,900,000.0	3,487,852.0	2,412,148.0	59.1
2	Сургалт семинар		2,000,000.0	650,000.0	1,350,000.0	32.5
3	Дотоод сургалт				0.0	
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,150,000.0	6,000,000.0	3,312,000.0	2,688,000.0	55.2
1	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	1,150,000.0	4,500,000.0	1,812,000.0	2,688,000.0	40.3
2	Ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж				0.0	#DIV/0!
3	Эмчилгээний төлбөр	1,150,000.0	1,500,000.0	1,500,000.0	0.0	100.0
НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН ДҮН		808,706,529.0	1,026,699,800.0	835,070,576.1	191,629,223.9	321.7
НИЙТ ОРЛОГЫН ДҮН		1,241,529.0	5,500,000.0	13,265,976.1	-7,765,976.1	241.2
1	Буулт, хөөрөлтийн орлого	627,616.0	3,000,000.0	5,162,377.8	-2,162,377.8	172.1
2	Зорчигч үйлчилгээний орлого		0.0		0.0	
3	Бусад орлого	613,913.0	2,500,000.0	8,103,598.3	-5,603,598.3	324.1
НИЙТ САНХҮҮЖИЛТИЙН ДҮН		807,465,000.0	1,021,199,800.0	821,804,600.0	199,395,200.0	80.5
4	Иргэний нисэхийн үндэсний төвийн санхүүжилт	807,465,000.00	1,021,199,800.00	821,804,600.00	199,395,200.00	80.474

### 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Иргэний нисэхийн үндэсний төв Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын эрхэм зорилго нь “Нисэхийн аюулгүй байдлыг найдвартай ханган, агаарын тээврийн ая тух, түргэн шуурхай үйлчилгээг бий болгож, зорчигчдод соёлч боловсон үйлчлэх нь бидний эрхэм зорилго мөн” гэж тодорхойлсон.

Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг “Нисэхийн аюулгүй үйл ажиллагаа болон нисэхийн аюулгүй байдлыг хангаж, зорчигч тээврийн үйлчилгээг чанартай хүргэх” гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Иргэний нисэхийн үндэсний төв ТӨААТҮГ Баянхонгор аймаг дахь салбар гэсэн статустай байна.

#### 3.2 Компанийн гадаад дотоод орчин

Иргэний нисэхийн үндэсний төв Баянхонгор аймаг дахь Нисэх буудал нь 1956 оны 06 дугаар сарын 18-ны өдөр байгуулагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр

заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах,” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт орсон, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа ба байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Иргэний нисэхийн үндэсний төв Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ИНЕГ-ын даргын 2021 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн А/124 дугаар тушаалаар шинэчлэн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгож байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг нь НББ-ын стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон болно.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Иргэний нисэхийн үндэсний төв Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэгдсэн ба тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	43,210.3	25,206.1	(18,004.2)
Авлага	7,195.0	6,965.4	(229.6)
Бараа материал	32,692.0	42,956.0	10,264.0
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	516.0	516.0
Үндсэн хөрөнгө	7,126,856.3	7,564,318.2	437,461.9
Хуримтлагдсан элэгдэл	5,014,027.3	5,136,188.2	122,160.9
Хойшлогдсон татварын хөрөнгө	10,426.9	10,668.6	241.7
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,135,886.9</b>	<b>2,443,568.8</b>	<b>307,681.9</b>
Өр төлбөр	169.9	-	(169.9)
Эздийн өмч	1,519,736.5	1,886,462.3	366,725.8
Өмч: - төрийн	1,030,960.0	1,030,960.0	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	488,776.5	855,502.3	366,725.8
Хуримтлагдсан ашиг	615,980.4	557,106.4	(58,874.0)
Эздийн өмчийн дүн	2,135,716.9	2,443,568.8	307,851.8
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,135,886.9</b>	<b>2,443,568.8</b>	<b>307,681.9</b>

005 ТӨРИЙН АУДИТ АЖИЛЛАГА  
ӨӨРЧЛӨЛТГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

Эх сурвалж: 2022 оны санхүүгийн тайлан

Төрийн банкин дахь харилцах дансны үлдэгдлийг дансны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулсан байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 18004.2 мянган төгрөгөөр буурсан нь ИНУТ-өөс авах санхүүжилт 821,804.6 сая төгрөгийн санхүүжилт авч бусад мөнгөн орлогоор 13,235.9 мянган төгрөг оруулж үндсэн үйл ажиллагаанд 835,044.7 мянган төгрөг зарцуулснаас шалтгаалсан байна.

Авлага дансны үлдэгдэл 6,965.4 мянган төгрөг болж 229.6 мянган төгрөгөөр буурсан нь дотоодын авиа компаниас авах 4,218.9 мянган төгрөгийн авлага төлөгдсөн, НӨАТ-ын худалдан авалттай холбоотой 1,143.4 мянга, Синус Дочи ХХК-д 2022.12.30-ны өдөр материалын үнийг давхар шилжүүлснээс шалтгаалж 3,902.3 мянган төгрөгийн авлага шинээр үүссэн байна.

Хувь хүнээс авах авлагын дансны эхний үлдэгдэл 2,958.6 мянган төгрөгөөс оны эцэст 1,919.6 мянган төгрөг болж 1,039.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 42,956.0 мянган төгрөг болж 10,264.0 мянган төгрөгөөр өссөн нь сэлбэг хэрэгсэл 6,131.4 мянган төгрөгөөр буурч, түлш шатахуун 16,320.2 мянган төгрөгөөр өссөнтэй /ТС-1 онгоцны шатахуун/ холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,564,318.2 мянган төгрөг болж 437,461.9 мянган төгрөгөөр өссөн нь, ИНЕГ-ын 2022.12.26 ны 05/2242 албан бичиг, ТӨБЗГ-ын 2022.11.22-ны өдрийн Дугаар 520 тогтоолоор хуримтлагдсан элэгдлээр анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийн ашиглалтын хугацааг сунган 366,725.8 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосныг хөрөнгө үнэ төлбөргүй бүртгэсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 169.9 мянган төгрөгийг барагдуулж оны эцэст өглөггүй байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 2,443,568.7 мянган төгрөг болж 307,851.8 төгрөгөөр өссөн нь тайлант оны алдагдал 58,873.9 мянган төгрөг, үндсэн хөрөнгийг дахин үнэлж бүртгэж авсантай холбогдуулан хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл данс 366,725.8 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

### 3.5. Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Иргэний нисэхийн үндэсний төв Баянхонгор аймаг дахь Нисэх буудал нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2022.02.09-ны өдөр тус салбарын зардлыг 999,899.3 мянган төгрөгөөр баталж, тодотголоор 2022.11.04-ны өдөр Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2022 оны орлого, зарлагын төлөвлөгөөг 1,026,699.8 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 5,500.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,026,699.8 мянган төгрөгөөр тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 13,266.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, Иргэний нисэхийн ерөнхий газраас 821,804.6 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна. Орлогын эх үүсвэр нь буулт хөөрөлтийн орлого, бусад орлогоос бүрджээ.

Нийт зардлын гүйцэтгэл 849,142.5 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 177,557.3 мянган төгрөгөөр хэмнэлттэй буюу 82.7 хувиар гүйцэтгэлтэй байна. Энэ нь тайланд онд төсвийн хэмнэлтийн горимд шилжсэнтэй холбоотой гол нөлөө үзүүлсэн байна.

Энэ нь 2022 онд 2 оронтой сул, 2022 оны 11 сарын 7-аас эхлэн 7 албан хаагч сул зогсолтын горимоор буюу үндсэн цалингийн 70 хувиар цалинжиж байгаа, Төрийн

хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн илүү цагийг өөрийн биеэр эдлүүлж байгаатай холбогдуулан 132,532.6 мянган төгрөгийн хэмнэлт гарсан байна.

Тус байгууллагын орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Хүснэгт 2. 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/мянган төгрөг

ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны гүйцэтгэл	2022 оны Тодотгол		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
НИЙТ ЗАРЛАГА	803,489.2	1,026,699.8	849,142.5	177,557.3	82.7
НИЙТ УРСГАЛ ЗАРДАЛ	803,489.2	1,026,699.8	849,142.5	177,557.3	82.7
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	802,339.2	1,020,699.8	845,830.5	174,869.3	82.9
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	483,306.3	601,220.8	486,339.5	114,881.3	80.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимт	66,635.1	75,152.6	57,501.3	17,651.3	76.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,468.7	59,552.8	57,741.3	1,811.5	97.0
Хангамж, бараа материалын зардал	70,666.4	80,372.1	77,209.1	3,163.0	96.1
Нормативт зардал	2,250.0	17,285.0	17,285.0	0.0	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	93,029.5	113,591.3	106,159.0	7,432.3	93.5
Томилолт, зочны зардал	14,108.2	18,000.0	20,300.4	-2,300.4	112.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төл	17,875.1	47,625.2	19,157.1	28,468.1	40.2
Бараа үйлчилгээний бусад зардал	2,000.0	7,900.0	4,137.9	3,762.1	52.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,150.0	6,000.0	3,312.0	2,688.0	55.2
НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН ДҮН	808,706.5	1,026,699.8	835,070.6	191,629.2	321.7
НИЙТ ОРЛОГЫН ДҮН	1,241.5	5,500.0	13,266.0	-7,766.0	241.2

Эх сурвалж: Иргэний нисэхийн үндэсний төв Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2022 оны орлого, зардлын төлөвлөгөө

#### 4. Аудитын тайлан

##### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Иргэний нисэхийн үндэсний төв Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг дарга Д.Мөнхжаргал танд танилцуулж байна

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад төрийн өмч, хөрөнгийн зарцуулалт, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цэням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Иргэний нисэхийн үндэсний төв Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2022 оны санхүүгийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дүгээр сарын 15-ны өдөр ирүүлсэн.

Тайлант жил хөрөнгө зарцуулахад нэгдүгээр гарын үсгийг Д.Мөнхжаргал томилогдсон бөгөөд хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Д.Одончимэг нар зурсан байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус байгууллагын 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 31-ны өдрийг дуустал хугацааны үйл ажиллагаанд Иргэний нисэхийн ерөнхий газрын дотоод аудитын албанаас 2022 оны 04 дүгээр сард дотоод аудит, хяналт шалгалт хийсэн байна.

Дотоод аудит, хяналт шалгалтаар нийт 16 заалт бүхий алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн ба “Иргэний нисэхийн ерөнхий газрын дотоод аудитын хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг залруулах ажлын төлөвлөгөө”-г газрын даргаар батлуулан төлөвлөгөөний биелэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 151 тоот албан бичгээр Иргэний нисэхийн ерөнхий газарт хүргүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,044,651.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 15,669.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 10,968.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжүүлснээр нийт 173,407.6 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ. Үүнд:

- Нислэгийн мэдээллийн ажилтны 1 орон тоо, уурын зуухны галч /гэрээт/ 1 орон тоо нийт 2 орон тоо ажиллаагүй, илүү цагаар ажилласан ажиллагсдад биеэр эдлэх амралтыг олгосон, 2022 оны 11 сараас 7 ажилтан сул зогсолтын горимд шилжин үндсэн цалингийн 70 хувиар цалинжуулснаар цалин, НДШ-ын зардлыг 132,532.6 мянган төгрөгөөр хэмнэсэн.

- Байр ашиглалтын зардлыг 1,811.5 мянган төгрөг, хангамжийн бараа материалын зардлыг 3,163.0 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 7,432.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

- Газрын төлбөрийн зардлыг 27,539.1 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 715.9 мянган төгрөг зарцуулсан нь нисэх онгоцны хөөрөх, буурах талбайг хөдөө аж ахуйн эдэлбэр газраар бус нийтийн эзэмшлийн газар болгон өөрчлөн газрын татварыг төлсөнтэй холбоотой байна.

#### **4.4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тендер шалгаруулах худалдан авах ажиллагаа-2, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 823,414.6 мянган төгрөгийн 25 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 56,997.6 мянган төгрөгийн 9 гүйлгээ, өмч хөрөнгөтэй холбоотой 50,306.9 мянган төгрөгийн 22 шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитыг 2022.09.29-2022.10.05-ны хооронд гүйцэтгэн нөөцөд байгаа ТС1 онгоцны шатахуун болон үндсэн үйл ажиллагаанд зарцуулсан шатахууны худалдан авалт, зарцуулалтыг үзэж холбогдох зөвлөмжийг хүргүүлж хэрэгжүүлсэн байна.

##### 4.5.2. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар нийт 35,411.7 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс, 33,797.4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1,614.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	33,797.4	1	33,797.4	0	0	0
Зөвлөмж	1	1,614.3	1	1,614.3			
Нийт дүн	3	35,411.7	3	35,411.7	0	0	0

Эх сурвалж: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын статистик мэдээ

#### 4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Авлагын дансанд бүртгэлтэй Г.Батмөнхтэй холбоотой 1,323.6 мянган төгрөг авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

#### 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,052.8 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулж, зөрчил давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг өгөв. Үүнд:

- 2022 оны 5-р сард Онцгой байдлын 111 дугаар ангийн Дундговь аймгийн нисэх буудлаас сумласан ТС-1 шатахууны нөөцийг нярвын тайланд нягтлан бодох бүртгэлээс 81.75 кг буюу 223.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байсныг нярвын тайланд зөв бүртгэж залруулсан.

- 2022 оны 9 сарын 30-нд шатахууны үнэ 3,829.1 мянган төгрөгийг Баянхонгор аймгийн НИК ХХК-руу шилжүүлж 767.7 л дизель, 540 л АЙ-92 бензинийг жолоочид хүлээлгэн өгснийг

005

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ӨӨРЧЛӨЛТГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

нягтлан бодох бүртгэлд нягтлан бодогч шууд зарлагаар бүртгэснийг залруулж жолоочид албаны хэрэгцээнд олгож буй шатахууныг жолоочийн замын тооцооны хуудсыг үндэслэн санхүүгийн программд зарлагдаж байх, хэрэв шатахууны талоны үлдэгдэлтэй тохиолдолд бараа материалын тайланд шатахууны үлдэгдлээр тайлагнаж, нярвын тайлангийн үлдэгдлийг тулган баталгаажуулж байх зөвлөмж өгөв.

Аудитаар нийт 1,737.2 мянган төгрөгийн 1 зөрчил илэрч зөрчил давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

## **5.1 Зөвлөмж**

### **1. Бараа материалтай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Байгууллагын бэлэн байдалтай холбоотой цахилгааны эх үүсвэр болох АД-100, кипор, лп-4 дизель гурван төрлийн моторт олгож буй шатахууныг нягтлан бодогч олгосон бүтэн дүнгээр зарлагдаж моторын нөөцөд байгаа шатахууны үлдэгдлийг нярвын тайланд үлдэгдлээр тайлагнаж санхүүгийн тайлан бүртгэлд тусгагдахгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.5 “хэмжигдэхүйц байх”, 13.4.”Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.” гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын бэлэн байдалтай холбоотой цахилгааны эх үүсвэр болох АД-100, кипор, лп-4 дизель гурван төрлийн моторт олгож буй шатахууныг моторын мот цагийг гүйлтийг үндэслэн зарлагдаж, моторын банк болон нөөцөд байгаа шатахууныг үлдэгдлээр бүртгэж, аудитаар илэрсэн үлдэгдлийг орлого авч НББ-д бүрэн тусгах зөвлөмжийг хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
2022 оны 5-р сард Онцгой байдлын 111 дугаар ангийн Дундговь аймгийн нисэх буудлаас сумласан ТС-1 шатахууны нөөцийг нярвын тайланд нягтлан бодох бүртгэлээс 81.75 кг буюу 223.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	1	223.7					1	223.7				
2022 оны 9 сарын 30-нд шатахууны үнэ 3,829.1 мянган төгрөгийг Баянхонгор аймгийн НИК ХХК-руу шилжүүлж 767.7 л дизель, 540 л АЙ-92 бензинийг жолоочид хүлээлгэн өгснийг нягтлан бодох бүртгэлд нягтлан бодогч шууд зарлагаар бүртгэсэн.	1	3,829.1					1	3,829.1			1	0
Дүн	2	4,052.8					2	4,052.8			1	0

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын бэлэн байдалтай холбоотой цахилгааны эх үүсвэр болох АД-100, кипор, лп-4 дизель гурван төрлийн моторт олгож буй шатахууныг нягтлан бодогч олгосон бүтэн дүнгээр зарлагдаж моторын нөөцөд байгаа шатахууны үлдэгдлийг нярвын тайланд үлдэгдлээр тайлагнасан.	1	1,737.2					1	1,737.2				
Дүн	1	1,737.2					1	1,737.2				